



В.В.СУРИН

ОХУ-ын Ял эдлүүлэх
Холбооны албаны
харьяа Пермийн дээд
сургуулийн сургалт
эрхэлсэн дэд захирал,
доктор/Ph.D/, дотоод
албаны хурандаа

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ХОЛБООНЫ АЛБА БА ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ОРЧИН ЦАГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Түлхүүр үг

Ял эдлүүлэх тогтолцоо, хууль
сахиулах байгууллагууд, хамтын
ажиллагааны хэлбэрүүд, олон улсын
харилцаа

Өнөөгийн нийгмийн өмнө олон
тулгамдсан асуудал байдаг ба түүний
нэг нь гэмт хэрэг юм. Энэхүү сөрөг
үзэгдэлтэй төрийн байгууллага болон
нийгмийн бүхий л салбар нэгж, салаа
мөчир бүр тэмцэх үүрэгтэй. Эдгээр
байгууллагуудын дотроос юуны өмнө
цагдаа, прокурор, шүүх болон шийдвэр
гүйцэтгэлийн байгууллага зайлшгүй
чухал үүрэгтэй болохыг онцолж байна.
Тэдний хувьд хууль сахин хэрэгжүүлэх
шийдвэрийг иж бүрэн болгохын тулд
нийтлэг зорилго, зорилт, байгууллага
хоорондын уялдааг хангасан механизм
байдаг бөгөөд эдгээр нь тэдний хүчин
чармайлт, үр ашигтай хамтын
ажиллагааг бий болгох үндсэн нөхцөл
болдог.

Хууль сахиулах болон хэрэгжүүлэгч
байгууллагуудын хамтын ажиллагааг
дараах хүчин зүйлээр нөхцөлдүүлдэг.

- Хууль сахиулах тогтолцоон дахь
чиг үүрэг, зориулалт;
- Чиг үүргээ хэрэгжүүлэх нэгдсэн
объект;
- Тусгай хүч хэрэгсэл, арга, техник
хэрэглэдэггүй бусад алба, нэгж хэсгийг
ашиглах;
- Чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа
шуурхай эрэл хайгуулын ажлыг
хэрэгжүүлэх байдал;

- Нэгдсэн нормативтай¹⁷⁰ байх
зэрэг болно;

“Хамтын ажиллагаа” гэдэг
философийн ухагдахууны утгыг авч
үзвэл янз бүрийн объектүүд харилцан
нэг нь нөгөөдөө үйлчилж, харилцан
нөхцөлдсөнөөр тэдгээрийн бүтэц
өөрчлөгдөх, харилцан шилжих
түүнчлэн нэг нь нөгөө объектоо үүсгэх
зэрэг үйл явцыг хэлнэ. Хамтын
ажиллагааг өөр үгээр тайлбарлавал:
“Аливаа юмс үзэгдлийн харилцан
хэлбэр дүрсийг нь бий болгодог хоёр
болон түүнээс олон биес болон үзэгдэл
харилцан үйлчилж тогтолцоог бий
болгодог бөгөөд үр дүнд нь хөдөлгөөн
үүсэх эерэг үйлдэл үүсэх, хөдөлгөөн
өөрчлөгдөх шалтгаан болдог”¹⁷¹

Эндээс шийдвэр гүйцэтгэлийн
тогтолцоо нь бусад субъекттэй хамтын
ажиллагааг зохион байгуулахдаа юуны

¹⁷⁰ См.: Грищенко А.И. Взаимодействие между аппаратами уголовного розыска и оперативными аппаратами ИТУ в предупреждении рецидива преступлений со стороны лиц освобождённых из исправительно-трудовых учреждений.: Дисс ... канд. Юрид. Наук М., 1987. С. 33

¹⁷¹ Философский энциклопедический словарь. – М., 1983. С.81.

өмнө зөвхөн хамтын хүчин чармайлтын үед л зайлшгүй хэрэгжүүлж чадах үйл ажиллагааны төрлүүдийг сонгож, онцлох нь зайлшгүй чухал юм.

Орчин үеийн нийгмийн харилцааны нарийн төвөгтэй шинж байдал нь ял эдлүүлэх тогтолцоог бусад субъектүүдтэй зайлшгүй хамтран ажиллахаар болгож байна.

Орчин үеийн нөхцөлд ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх алба өмнөө тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлэхийн тулд улс орныхоо болон гадаад улс орны хууль сахиулах байгууллагатай идэвхитэй хамтран ажиллаж байна. Энэ утгаараа бид хамтын ажиллагааны хэлбэрийг олон улсын, үндэсний хэмээн хоёр хувааж болно. Эдгээр хэлбэрийг тус бүрд нь дэлгэрэнгүй авч үзье.

Ял эдлүүлэх тогтолцооны олон улсын хамтын ажиллагаа маш олон талтай байдаг.

Нэг. ОХУ-ын нутаг дэвсгэрт ял эдэлж байгаа гадаад орны иргэнд хууль эрх зүйн болон хүмүүнлэгийн шинж чанартай хамтын ажиллагааг зохион байгуулах үндэслэл учир шалтгаан байдаг.

Хоёрт. Олон улсын холбогдох гэрээ хэлэлцээрийг дагуу ОХУ-ын нутагт ял эдэлж байгаа гадаадын иргэдийг тухайн улс руу нь ял эдлүүлэхээр шилжүүлэх, мөн гадаад улс оронд ял эдэлж байгаа ОХУ-ын иргэдийг ОХУ-ын ял эдлүүлэх байгууллагад хүлээж авах асуудал байдаг.

Гуравт. Олон улсын эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулахад хамтын ажиллагааг

хэрэгжүүлэх явдал юм. Хорих ял эдэлж байгаа ялтан оргон зайлж ОХУ-ын нутаг дэвсгэрээс гарч, өөр улс оронд хоргодож болно. Хэдийгээр практик дээр энэ нь туйлын ховор тохиолддог боловч байдаг зүйл юм.

Олон улсын эрэн сурвалжлах ажиллагаа гэдэг нь санаачлагч орны болон гадаад улс орны эрх бүхий байгууллагын цогц шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа, мэдээлэл-лавлагаа болон бусад үйл ажиллагааг хэлнэ. Олон улсын эрэн сурвалжлах ажиллагааг тухайн улс интерполын үндэсний товчоогоор уламжлан олон улсын эрх зүйн хэм хэмжээ, тухайн орны дотооддоо мөрдлөг хууль эрх зүйн баримт, дүрэм журмыг мөрдлөг болгон оролцогч орон бүр хэрэгжүүлдэг.

ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх алба болон бусад төрийн байгууллага хамтран гадаад улс орны хууль сахиулах байгууллагатай хандан оргон зайлсан гэмт хэрэгтэнг илрүүлэхэд чиглэсэн шуурхай эрэн сурвалжлах, мэдээлэл-лавлагаа гаргах зэрэг чиглэлээр болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг.

Оргон зайлсан ялтанг ОХУ-ын Дотоод хэргийн яам, Холбооны ял эдлүүлэх албаны идэвхтэй хамтын ажиллагааны үр дүнд олж илрүүлэх боломжтой.

Гэмт хэрэгтэй хамтран тэмцэх олон улсын хамтын ажиллагааны үндсэн баримт бичиг нь ОХУ-ын ДХЯ-ны 786-р тушаал, ОХУ-ын Хууль зүйн яамны 310-р тушаал, ОХУ-ын Аюулаас хамгаалах газрын 470-р тушаал, ОХУ-ын ФСО-ийн 454-р, ОХУ-ын ФСКН-ын

333, ОХУ-ын ФТС-ын 971-р хамтарсан 2006 оны 10-р сарын 6-нд гаргасан тушаалаар “Интерполийн шугамаар мэдээллээр хангах ажиллагааг зохион байгуулах зааварчилгааг батлах тухай” гэсэн баримт бичиг байдаг бөгөөд үүний үндсэн дээр ОХУ-ын ДХЯ, болон бүх сонирхсон субъект түүн дотроо Холбооны ял эдлүүлэх албатай харилцаж болно.

Олон улсын хамтын ажиллагааны дөрөв дэхь элемент бол шинжлэх ухаан- боловсролын хэсэг юм. Энд юуны өмнө боловсон хүчин бэлтгэх, давтан бэлтгэх асуудлыг чухалчлах хэрэгтэй. ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албаны тогтолцоонд 6 дээд сургууль байдаг бөгөөд төрөл бүрийн мэргэжлээр сонсогч, оюутныг шийдвэр гүйцэтгэлийн байгууллагуудад бэлтгэдэг, Монгол Улсад бол Хууль сахиулах их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль энэ чиг үүргийг хэрэгжүүлдэг. ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албаны сургалтын төвүүдэд Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэргэжил нэгтнүүдээ сургах, мэргэжил дээшлүүлэх ажлыг хийж байна. (Тухайлбал, Буриад дахь сургалтын төвийг нэрлэж болно.)

2015 онд ОХУ-д суугаа Монгол улсын элчин сайдын яаманд ажлын хэсгийн уулзалт болсон. Энэ уулзалтанд ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албаны орлогч захирлын үүрэг гүйцэтгэгч Вамрий Макелменко, Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын төлөөлөгчтэй харилцан ажил хэрэг ярих явцдаа ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албаны

сургалтын төвүүдэд хамтын ажиллагааны хүрээнд Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах, бүр өргөжүүлэх явдал чухал ач холбогдолтой болохыг цохон тэмдэглэж байсан. Манай хоёр орны тухайд эрдэм шинжилгээний ажилтан солилцох, тэргүүн туршлага бүхий материал харилцан илгээх ажил хийж байна. Тухайлбал харуул хамгаалалт, хуяглан хүргэх, хүний эрхийг хангах чиглэлээр холбооны ял эдлүүлэх албаны Перм хотын дээд сургуулийн ажилтнуудын бэлтгэсэн 20 гаруй нэгж сургалт, эрдэм шинжилгээ, арга зүйн ном зохиолыг Монгол улсын Хууль зүйн яамны Хууль сахиулахын Их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн сургалтын процесст нэвтрүүлэн хэрэглэж байна.

Нийгмээс тусгаарлан таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоогүй шийтгэлүүдийг хэрэгжүүлэх асуудал 2 талын сонирхлыг ихээхэн татаж байгаа юм. Энэ болон бусад тулгамдсан асуудлаар ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албаны сургалтын төвүүдээр зохион байгуулагддаг олон улсын эрдэм шинжилгээ, практикийн хурлууд дээр шүүн хэлэлцэж байна. Тухайлбал, 2014, 2015 онуудад ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албаны Перм хотын дээд сургуульд зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээ-практикийн хурал “Ял эдлүүлэх тогтолцоо ба нийгэм: туршлага хамтын ажиллагаа” сэдвээр болсон бөгөөд Монгол улсын

Хууль сахиулахын их сургуулийн төлөөлөл амжилттай оролцсон. Мөн 2014 онд ОХУ-ын Ял эдлүүлэх албаны академиас “Орчин үеийн нийгэм дэх ял эдлүүлэх тогтолцоо, түүний хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээ-практикийн бага хурал, 2014 онд ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албаны Киров хотын салбар “Хоригдогсдыг хөгжингүй иргэний нийгэмд дахин нийгэмшүүлэх нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээ-практикийн хурал болсон. Эдгээр хуралд Монгол улсын төлөөлөгчид оролцох явдал уламжлал болсон гэж хэлж болно. Эрдэм шинжилгээ-практикийн хуралд оролцох явцдаа байгууллага хоорондын хамтын ажиллагаа, ял эдлүүлэх албаны бусад салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг ярьж байна.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд түлхүүр асуудалд тогтолцооны ажлын талаар иргэдэд мэдээлэх, олон улсын төвшинд байгууллагын албаны болон боловсролын нэр хүндийг нэмэгдүүлэх, гэмт хэргийн эсрэг тулгамдсан асуудлаар хамтарсан эрдэм шинжилгээ судалгааны ажлууд хийх зэргийг оруулж болох юм.

Хоёр орны ял эдлүүлэх албаны хооронд 2015 оны 9-р сард хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлийн санамж бичигт гарын үсэг зурахаар төлөвлөж байгаа. Энэ нь хэрэгжвэл олон улсын хамтын ажиллагааг 2 орны хувьд цоо шинэ төвшинд гаргах юм.

ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх алба, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа олон талтай. Энэ тухай ярихдаа үндэснийхээ хамтын

ажиллагааны хэд хэдэн хэлбэрийг онцлох нь зүйтэй гэж үзэж байна.

Нэг. Шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа явуулахад хамтын ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд үүнийг 1995 оны 8-р сарын 12-нд баталсан №144-ФЗ “Шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагааны тухай” хуулиар баталгаажуулсан байдаг. Энэ хуулинд ялангуяа, эрх бүхий байгууллагын шуурхай ажлын хэсгийн ажилтнууд шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ял эдлүүлэх албаны ажилтнуудтай хамтран таслан сэргийлэх үйл ажиллагаа явуулах эрхтэй болохыг (зүйл 13-т) тусгаж өгсөн. Мөн ОХУ-ын Эрүүгийн хуулийн 84-р зүйлд ОХУ-ын хорих байгууллагын шуурхай эрэн сурвалжлах ажлын нэг үндсэн чиг үүрэг нь иргэнийг ял эдлэх газартаа очихоос өмнө цагдан хоригдох хугацаанд нь хэргийг илрүүлэхэд туслах явдал байдаг гэдгийг хуульчилж өгсөн байдаг.

Ийм учраас шуурхай эрэн сурвалжлах хэсгийнхний байнгын шуурхай харилцаа холбоогоор хангаж, мэдээллийг шуурхай солилцуулж байх шаардлага гардаг. (Үүнийг хуульчилж ч болох юм гэж үздэг). Практик дээр дотоод хэргийн байгууллагын ажилтнууд ихэвчлэн баривчлагдсан иргэн оргон зайлсан, шалгагдаж байгаа иргэн дуудсан хугацаанд ирээгүй, хугацаа хэтэрч ирсэн зэрэг зөрчил гаргахад эрэл хайгуул хийх, баривчлах ажил хийж шийдвэр гүйцэтгэлийн

байгууллагатай хамтран ажилладаг гэдгийг хэлэх хэрэгтэй.¹⁷²

Хоёрт. Гэмт хэргийг мөрдөн шалгах явцад хоригдож байгаа хүмүүстэй зайлшгүй хамтран ажиллах шаардлага гардаг. Хэдийгээр хорих байгууллагын захиргаа гэмт хэргийн талаар урьдчилан мөрдөн байцаалт явуулах эрхгүй гэдгээр дотоод хэргийн байгууллагын ажилтнуудаас ялгаатай боловч ОХУ-ын гэмт хэргийн тухай хуулийн СП5Ч 2СТ.157 заалтын дагуу ял эдлүүлэх албаны удирдлага хойшлуулшгүй мөрдөн шалгах ажиллагааг тухайн байгууллагын гүйцэтгэх ажилтнуудаар хийлгэж болдог.

Гурав. Дотоод хэргийн байгууллага, ял эдлүүлэх байгууллага хэрэгтэнг шилжүүлэхдээ зайлшгүй хамтран ажиллах үүрэгтэй. ОХУ-ын ял эдлүүлэх хууль тогтоомжийн дагуу ялтан ял эдлэх газраа холбогдох бүртгэлийг хийлгэдэг бөгөөд энэ тухай дотоод хэргийн байгууллагад мэдээлэл өгдөг.

Дөрөв. Дотоод хэргийн байгууллагын тусламж ял эдлүүлэх албанд зайлшгүй хэрэгтэй болох тохиолдлууд байдаг. Тухайлбал, байгалийн гамшиг тохиолдох, засан хүмүүжүүлэх газар байгаа нутагт онц байдал зарлах буюу дайны нөхцөл байдал үүсэх үед, бүх гэм зэмгүй шүүгдэгчийг хүчлэн хамгаалах зэрэгт дэмжлэг тусалцаа хэрэгтэй болдог. Энэ тохиолдолд дотоод хэргийн

байгууллагын үндсэн чиг үүрэг иргэдийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг ял эдлүүлэх албаны ажиллагсдын хүчээр хамгаалж дийлэхгүй зай талбай байршилд хангах явдал юм.

Тав. Дотоод хэргийн байгууллага нь “Эрх чөлөөгөө хасуулж ял эдэлж байгаад суллагдаж ирсэн хүмүүст захиргааны хяналт тавих тухай” ОХУ-ын хуулийн дагуу суллагдаж ирсэн хүмүүст захиргааны хяналт заавал тавьж ажиллах үүрэгтэй. Түүнчлэн хорих байгууллагын ажилтнууд доорхи ажлыг дарааллын дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

1. Шүүхээс ногдуулсан ялын хугацаа дуусахаас 2 сараас багагүй хугацааны өмнө шүүхэд хандаж, тухай ялтанг суллагдсны дараа захиргааны хяналтад байлгах тухай өргөдөл гаргана.

2. Суллагдах иргэнийг захиргааны хяналтад байлгахыг зөвшөөрсөн шүүхийн албан ёсны шийдвэр ирсний дараа 7 хоногийн дотор ялтны өөрийн нь сонгосон буюу амьдарч байсан хаягаар нь уг шийдвэрийн хуулбар хувийг дотоод хэргийн байгууллагад хүргүүлнэ.

3. Тухайн ялтанг суллагдах үед захиргааны хяналт тогтоосныг мэдэгдэж, очих газраа тогтоосон хугацаанд очиж захиргааны хяналтын бүртгэлд хамрагдах шаардлагатай, эс үйлдвэл хуулийн дагуу хариуцлага хүлээх болно гэдгийг сануулж гарын үсэг зуруулдаг.

Зургаа. Дотоод хэргийн байгууллага нь ял эдлүүлэх байгууллагатай ялтан суллагдсныхаа

¹⁷² Крымов А.А., Фомин В.В. Взаимодействие ОВД и УИС по предупреждению и раскрытию преступлений: учеб.-практ. Пособие. –Рязань: Академия ФСИН России, 2013. -23 с.

дараа дахин шинэ гэмт хэрэг үйлдэхгүй байх талаар урьдчилан сануулах, бусад ажиллагааг хамтран хэрэгжүүлэх үүрэгтэй.¹⁷³

Дотоод хэргийн байгууллага ял эдлүүлэх албаны хамтын ажиллагааны төрлийг бүгдийг нь тоочих боломжгүй учраас чухал гэж үзсэн цөөн хэдэн хамтын ажиллагааны хэлбэрийг дурьдлаа.

Практик дээр хамтын ажиллагааны хувьд шийдэгдээгүй олон асуудал байдаг бөгөөд энэ бүгд энэхүү хамтын ажиллагааг хөгжүүлэх урьдчилсан нөхцөл болдог. Иймэрхүү тулгамдсан, хүндрэлтэй гэж үздэг асуудлаар судалгаа хийж үзэхэд дараах үр дүн гарсан байна. Үүнд:

- Байгууллагуудын нэгдмэл бус байдал (37%)
- Хамтын ажиллагааны холбогдох асуудлуудаар төгс төгөлдөр болоогүй байгаа (23%)
- Доод төвшинд хамтын ажиллагааны талаахи туршлага, мэдлэг хангалтгүй байгаа (18%)
- Зорилго, зорилтын нэгдмэл байдал хангалтгүй (17%)
- Хамтран ажиллах шаардлагагүй гэж үзэх хувь хүний байр суурь бодол (амбиц) (14%)
- Санхүү, материал техникийн хангалт муу (14%)¹⁷⁴

¹⁷³ Остапенко Н.И. Проблемы взаимодействия сотрудников подразделений по делам несовершеннолетних и оперативных уполномоченных уголовного розыска в предупреждении преступности подростков, осужденных к условной мере наказания //Рос.следователь. 2007. № 9. С. 23-26.

¹⁷⁴ Барабанов Н.П., Власов А.Н. Факторы, Обуславливающие взаимодействие оперативных подразделений органов внутренних дел и

Энэ судалгаанаас харахад ОХУ-ын дотоод хэргийн байгууллага, ял эдлүүлэх алба, ер нь дотоод гадаад гэлтгүй хамтын ажиллагааны үр дүн, чанар, үр өгөөжийг дээшлүүлэх арга замыг хайх шаардлага байна гэсэн дүгнэлт гарч байна.

Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн хувьд хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөрүүд нь зөвхөн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын хамтын ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх төдийгүй бусад субъектэд ч ихээхэн ач холбогдолтой байдаг.

Хамтын ажиллагааны үр ашгийг дараах чиглэлээр сайжруулах арга байгаа гэж бид үзэж байгаа юм.

- Олон улсын хамтын ажиллагаа, ялангуяа хоёр талын гэрээ, хэлэлцээр байгуулах асуудал нэн чухал байна.
- Шуурхай ажлын хэсгийн үйл ажиллагааг нэгдсэн мэдээллийн автоматжуулсан сүлжээгээр хангах, түүндээ төрөлжүүлсэн мэдээллийн сан үүсгэж, шуурхай лавлагаа, шуурхай бүртгэлжүүлэлтээр хангах, гэмт хэрэг, зөрчил үүний хандлага, зүй тогтол, шалтгаан, нөхцөл байдлын талаар тухай бүр нь нэгтгэн дүгнэх, ашиглаж байх боломж бүрдүүлэх, түүнчлэн, энэхүү мэдээлэл нь тодорхой байршилд шуурхай ажиллах нөхцөл байдал үүссэхэд хууль сахиулах байгууллагын хүн, хүч, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд аюулгүй байдал, дэг журам хангаж чадах эсэхийг тооцоолох боломж бүрдүүлсэн байх хэрэгтэй.

уголовно-исполнительной системы. Формы его реализации: учеб.пособие. –Рязань: Академия ФСИН России, 2011. –Кн. 36. -47 с.

- Шуурхай бүлэг хүнд, онц хүнд гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай.

- Алба хэсгийг орчин үеийн технологийн шийдэл бүхий холбоо харилцаагаар хангаж, мэдээлэл-дүн шинжилгээний тогтолцоог хөгжүүлэх, улмаар нэгдсэн автоматчилагдсан сүлжээгээр статистик дүн мэдээг бүртгэх, баримт бичиг боловсруулах тогтолцоотой болох

- Ял шийтгэлээс зугтан зайлсан этгээд, түүнчлэн захиргааны болон иргэний эрх зүйн харилцааны төвшинд үүссэн хэргийг шуурхай эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулахтай холбоотой хууль эрхийн хэм хэмжээ тогтоосон баримт бичиг бэлтгэх, батлах

- Хэсэгт ажиллаж байгаа цагдаа, шийдвэр гүйцэтгэлийн ажилтны хяналт-шалгалт хийх эрх мэдлийг нэмэгдүүлэх, хорихоос бусад арга хэмжээ хэрэгжүүлэх чиг үүргийг өргөжүүлэх

- Гэмт бүлэглэлийн зүгээс ирэх ямарч дарамт шахалтыг давж, ямар ч нөхцөл байдалд ажиллаж чадах орчин цагийн шаардлага хангасан шинэ үеийн боловсон хүчнийг бэлтгэх, хүмүүжүүлэх зэргийг нэрлэж болно.

Орчуулсан Л.АЛТАНСҮХ

Хууль сахиулахын удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, хурандаа



*Л.Хаш
Санхүү эдийн
засгийн дээд
суруулийн
Эрх зүйн
тэнхимийн багш*

ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ БОЛОН МАРГААН ХЭРХЭН ЗОХИЦУУЛАХ

Монгол улсын худалдааны талаарх хууль болон худалдах, худалдан авах гэрээнд маргааныг хэрхэн зохицуулах талаар судаллаа.

УДИРТГАЛ

Энэхүү сэдвийн хүрээнд худалдах худалдан авах гэрээ нь энгийн хялбар хийгдэх боловч уг гэрээнээс үүсэх асуудлыг хэрхэн зохицуулах гэрээний ерөнхий ойлголт, үүрэг хариуцлага, эрхийн доголдол гэж юу болох түүнийг хэрхэн арилгуулах, өөрийн эрх ашиг сонирхлыг хэрхэн хамгаалах, маргаан таслан шийдвэрлэх ямар ямар арга замууд байдаг тэдгээрийн ялгаатай талууд мэдээж бизнесийн хүрээнд цаг хугацааг хурдан шуурхай явуулах.

Гадны хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж байгууллага Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахад гардаг зарим асуудал нь ихэвчлэн гэрээнээс үүссэн маргаан байдаг. Энэхүү гэрээнээс үүссэн маргаан шийдвэрлэхэд хурдан бөгөөд найдвартай шийдвэрлэх арга замыг тодорхойлох гэх асуудлууд урган гардаг тиймээс худалдах худалдан авах гэрээ болон ашигт